ХҮНИЙ ЭРХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ХҮЧИРХИЙЛЭЛ

Мэдээллийн багц-6

ХҮНИЙ ЭРХ гэж юу вэ?

Хүний эрх нь хүн бүрт төрөлхөөс заяагдсан, хүн болж төрсөн цагаас нь бий болдог төрөлх чанар юм. Хүн бүр арьсны өнгө, яс үндэс, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад байдлыг үл харгалзан ямар ч ялгаварлалгүйгээр эрхээ эдлэх ёстой. Тухайлбал биеэ үнэлэгч, гей, трансжендэр, баян, ядуу, аль улсын иргэн бэ гэдгээс үл хамааран хүн бүр тэгш эрхтэй. Хүний эрх бол хүн болж төрснийхөө хувьд нэр төртэй, үнэ цэнэтэйгээр амьдрахад зайлшгүй шаардлагатай хэм хэмжээ юм. Нэг хүний эрх чөлөө нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг.

Хүний заяамал буюу жам ёсны эрхүүд

- Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.
- Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй.
- Хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй.
- Хүн бүр хувийн өмчтэй байх эрхтэй.

Хүний эрх нь өөр хоорондоо салшгүй зүйл. Өөрөөр хэлбэл хүний нэг эрх зөрчигдөхөд нөгөө эрх нь давхар зөрчигдөж байдаг, хүний нэг эрх хангагдахад бусад эрх нь дагаад сэргэж байх жишээтэй. Мөн хүний эрхийг нэгийг нь нөгөөгөөс нь илүүд авч үзэж, эрэмблэх боломжгүй бөгөөд бүгд харилцан уялдаатай байдаг.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ гэж юу вэ?

Зорилтот бүлгийн хүн амд хамрагдаж буйн улмаас (жишээлбэл тухайн хүн гей, биеэ үнэлэгч гэх мэт) тухайн хүнд шударга бус хандах явдлыг ялгаварлан гадуурхах үйлдэл гэж тодорхойлно. Ялгаварлан гадуурхах үйл явцыг шууд болон шууд бус гэж хоёр хуваадаг.

Шууд ба шууд бусаар ялгаварлан гадуурхах

Шууд ялгаварлан гадуурхалт нь илтээр шударга бус, тэгш бус байдлаар харьцахыг хэлнэ. Тухайлбал биеэ үнэлдэг, эсвэл бэлгийн цөөнх, ДОХ-оор өвчилсөн учраас элдвээр нэрлэх, хочлох, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, таагүй харьцах гэх мэт.



Шууд бус ялгаварлан гадуурхалт нь өнгөн талаас нь үзэхэд шударга хандаж буй мэт боловч бусад бүлэг хүмүүстэй

харьцуулбал тухайн бүлэгт тэгш бус байдлаар нөлөөлөхийг хэлнэ. Жишээ нь: баривчлан хорих байранд хоригдож буй эмэгтэйчүүдэд ялгавартай ханддаг.

Ялгаварлан гадуурхах үзэл нь ихэнх тохиолдолд дутуу дулимаг мэдлэг, айдас, эсвэл буруу ойлголт, тогтсон хандлага болон нэр хоч, ташаа төсөөллийн үр дүн байдаг.

Ялгаварлан ядуурхалт, гутаан доромжлол нь хэний зүгээс ирдэг вэ?

1. Олон нийт өөрсдийгөө бусдаас өөр, нийгэмд үл хүлээн зөвшөөрөгдөх зүйл хийдэг хэмээн өөрөө өөрсдийгөө нийгмээс тусгаарлан ялгаварладаг.
2. Үйлчлүүлэгчийн зүгээс тэдэнтэй бүдүүлэг, ёс бусаар харьцах, гутаан доромжлох асуудал гаргадаг.

3. Олон нийтийн гэр бүл, ойр дотны зарим хүмүүс биеэ үнэлэх, бэлгийн цөөнх байх зэрэг нь байж болшгүй зүйл хэмээн үзэж, тэднийг элдвээр хэлж ялгаварлан гадуурхах хандлага түгээмэл байдаг.
4. Хуулийн байгууллага, үйлчилгээний газар, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд ч тэдэнд ямар нэг байдлаар ялгавартай ханддаг.
5. Нийгмийн зүгээс олон нийтийг ялгаварлан гадуурхах үзэгдэл хүчтэй илэрч байдаг.
6. Хэвлэл мэдээлэл хамгийн хүчтэй зэвсэг бөгөөд олон нийт эмэгтэйчүүдийг хүмүүст ихэнхдээ сөргөөр ойлгуулах ажлыг хийж зарим талаар ялгаварлан гадуурхалтыг дэвэргэдэг.



Ялгаварлан гадуурхалтын эсрэг юу хийх вэ?

Энэ бүх ялгаварлан гадуурхалтыг даван гарахад өөрийн үнэлэмж, өөртөө итгэлтэй байдал маш чухал.



Тэд, ялангуяа эмэгтэйчүүд ганцаараа биш нийтээрээ байж үзэл бодлоо хуваалцаж, нийгмийн хандлагад ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлохыг бууруулахад нөлөөлөх үйл ажиллагааг бодож төлөвлөн, хэрэгжүүлэх нь зүйтэй.

Ялгаварлан гадуурхалтыг зогсоохын тулд тэд өөрсдөөсөө эхлэх нь хамгийн зүйтэй алхам. Тухайлбал олон нийт өөрсдөө би биеэ үнэлдэг, эсвэл бэлгийн цөөнх тиймээс хүмүүс надад таагүй хандах нь байж болох зүйл гэх ойлголтоосоо нэн даруй салах хэрэгтэй. Хэдий тийм байлаа ч тэдэнд хүнлэг бус хандах ёсгүй.

Бидний зорилго бол хүн ёсны төрөлхөөс заяагдсан амьд явах, халдашгүй дархан байх, аливаа доромжлол, хүнлэг бус харьцаанаас ангид байх гэх мэт ойлголтыг олон нийтэд ойлгуулах явдал юм. Гол нь хэн байхаас үл хамаарч би бусдын адил эрхтэй гэдгээ алхам тутамдаа өөртөө хэлж байх хэрэгтэй. Ялгаварлан гадуурхалтыг даван гарахад хувь хүний мэдлэг маш чухал юм.

Хүний эрхийн баталгаа юу вэ?

Хүн бүр эрхээ эдэлж амьдрахыг хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан ба улс орон бүр иргэдийнхээ энэхүү эрхийг хүн бүрт тэгш эдлүүлэхийн төлөө хүний эрхийн баталгааг нь хангаж өгөх, хамгаалах, эрхийг нь нөхөн сэргээх үүрэгтэй. Хүнийг хэл амаар доромжилсон, алдар хүнд, нэр төрд нь халдсан, бие махбодийн гэмтэл учруулсан гэх мэт нь бүгд гэмт хэрэг ба энэ бүгдэд хуулийн хариуцлага тооцогддог. Ямар ч хуулинд хэрэв та биеэ үнэлж яваад зодуулсан, хэл амаар доромжлуулсан бол эрхээ хамгаалуулах эрхгүй өөрөө буруутан болно гэсэн заалт үгүй юм.

ХҮЧИРХИЙЛЭЛ гэж юу вэ?

Сэтгэл санааны хүчирхийлэл

- Аливаа хүсэл бодлыг нь үл ойшоох
- Нэр хоч өгөх
- Гутаан доромжлох
- Айлган сүрдүүлэх
- Загнах, зандрах
- Үл хайхрах
- Гүтгэх
- Мөрдөн мөшгөх
- Бусадтай харилцахыг хязгаарлах
- Өөртөө болон амьдралд итгэх итгэлгүй болох
- Заналхийлэх, улмаар амиа хорлоход хүргэх ба үүгээр хязгаарлагдахгүй.

Эдийн засгийн хүчирхийлэл

- Мөнгө, орлогоо захиран зарцуулах эрхэд халдах
- Ажилгүй болгох

- Эдийн засгийн эх үүсвэрээс нь салгах
- Орлого олох боломжийг нь хязгаарлах
- Тэжээн тэтгэхээс зайлсхийх
- Эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах
- Хэрэглээг нь хясан боогдуулах ба үүгээр хязгаарлагдахгүй.

Бэлгийн хүчирхийлэл

- Хүслийг үл харгалзан хүч хэрэглэх
- Хууран мэхлэх, айлган сүрдүүлэх замаар бэлгийн дур хүслээ хангах
- Бэлэг эрхтнийг нь гэмтээх, элдэв аргаар тарчлаах
- Бэлгийн хавьталд зүй бусаар орохыг шаардах, оруулах ба үүгээр хязгаарлахгүй.

Гэр бүлийн хүчирхийлэл

Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь буюу гэрлэсэн, урьд нь гэр бүлийн харилцаатай байсан, эсхүл хэзээ нэгэн цагт хамт амьдарч байсан бусад ойр дотны хүмүүсийн зүгээс хүч, эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор хяналтаа тогтоож, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус харилцаа юм.

Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр, түүний илрэлүүд

- Бие махбодийн хүчирхийлэл
- Алгадах, Өшиглөх, Зодох гэх мэтээр биед нь гэмтэл учруулах, эрүүл мэндээр нь хохироох
- Эд юмаар цохих, гэмтээх
- Түлэх, үсдэх
- Хутга, буу зэрэг хүйтэн зэвсэг хэрэглэн сүрдүүлэх
- Амь насыг нь хохироох, хохироохоор сүрдүүлэх ба үүгээр хязгаарлагдахгүй.

Хаана хандаж тусламж авч болох вэ?

Таны утас нэгжгүй байсан ч залгах боломжтой.

- Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага хүлээн авах, зөвлөгөө, мэдээлэл, өгөх утас: **107**
- Цагдаагийн мэдээлэл, шуурхай удирдлагын төв: **102**
- Хүүхдийн тусламжийн утас: **108**
- Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээ: **70180139**
- Шүүх эмнэлгийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээ: **70113408**
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв: **70119949**, зөвлөгөө өгөх утас - **96490505**

ТӨГС БҮСГҮЙЧҮҮД

Төрийн бус байгуулалга

БЗД 18-р хороо “Шинэ зуун” хотхон
24г-22 тоот
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:77055390
www.tugsbusguichuud.mn

Багцыг боловсруулсан: Ш.Лхагвасүрэн
Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Чулуунбат

ЭМЯ, Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.